ТАНИЛЦУУЛГА

2023 оны 12 дугаар сарын 08 Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг - Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь анх Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1962 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 363 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Ардын депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дэргэд “Улаанбаатар хотын Нийгэмлэгүүдийг удирдах товчоо” нэртэйгээр байгуулагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын бүтэц орон тоо өөрчлөгдөж, “Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн”, “Спорт, нийтийн биеийн тамирын” гэсэн зохион байгуулалтын 2 хэлтэс, 16 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.



Тус байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх зорилгоор нийслэлийн 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодыг удирдлагаар ханган ажиллаж байна.

Нийслэлийн иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлж, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, олон нийтийг хамарсан арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийг хамарсан 24 (“Цасны баяр”, “Өвлийн биеийн тамир, спортын наадам”, “СӨБ”, “ЕБС”-ийн багш, арга зүйчдэд зориулсан багц сургалт, “Цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастик”, “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастик”, “Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн биеийн тамирын өдөрлөг”, “Улаанбаатар марафон-2023” олон улсын гүйлт, “Алхацгаая гүйцгээе” хөдөлгөөн, “Иргэдийн

спортын наадам”-ын явган алхалт, “Нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдын спортын наадам”-ын явган алхалт, “Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”, Нийслэлийн Иргэдийн спортын наадам, Нутгийн захиргааны наадам гэх мэт) арга хэмжээг зохион байгуулж 2481 байгууллагын 416,000 иргэнийг хамруулсан бол нийслэл, дүүргийн хэмжээнд 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 834,000 иргэнийг хамруулсан.

Багийн спортын төрлөөр өсвөрийн хүүхэд, багачууд, иргэд, тамирчдын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээн, “Улаанбаатар цом” хөлбөмбөгийн тэмцээн, “Улаанбаатар лиг” волейболын тэмцээн, Монголын хүүхдийн спортын VII наадмын нийслэлийн бүсийн тэмцээнийг багийн спортын 5 төрлөөр тус тус зохион байгуулж 298 байгууллагын 145,350 хүүхэд, багачууд, тамирчид хамруулсан.

Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдээр Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмадын ангиллаар 30 төрлөөр 375 багийн 7967 тамирчин оролцсон бөгөөд шинэ тутам хөгжиж буй спортын төрлүүдийг нэмэгдүүлэх зорилгоор снөүбоард, виртуаль дугуй, шорк трейк төрлийг зохион байгуулагсан.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар Дүүргийн Засаг дарга нарын дэргэд өсвөрийн шигшээ багийг спортын 28 төрлөөр байгуулж, 105 дасгалжуулагч, 2944 тамирчин хичээллэж байна.

Биеийн тамир, спортын спортын барилга, байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 онд Баянзүрх, Налайх, Багахангай дүүргийн спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлэхээр улсын төсөвт 5,043.6 сая төгрөг батлагдсан бөгөөд тус 3 цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл 82 хувьд хүрсэн.

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР